

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/089/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn СМД аудит ХХК-ийн Аудитын менежер: Б.Мөнхцацрал Утас: 99110699 Цахим хаяг: munkhtsatsral@cmdaudit.mn Аудитор: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.08.11 № 29

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллагын улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 56,500.3 мянган төгрөгөөр буурч, орон нутгийн төсвийн санхүүжилт 96,872.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд хандиваар ирсэн 20,304.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 36,523.0 мянган төгрөгийн элэгдлээрээ өртгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн 25,498.0 мянган төгрөгөөр үнэлж бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудал

Тайлант онд 1 хөтөлбөр, 5 зорилт, 98 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 93 арга хэмжээг бүрэн, 5 арга хэмжээг дутуу

ЧАНДМАНЬ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
П.ЛХАНЗМАА ТАНАА

822505000075

хэрэгжүүлж, биелэлтийг 90.0 хувиар үнэлж хүргүүлсэн бөгөөд аймгийн Боловсролын газраас 83.0 хувиар “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	234,456,210.75	123,101,059.07
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	170,331,632.75	48,307,635.07
312	Банканд байгаа бэлэн мөнгө	170,331,632.75	48,307,635.07
3121	Төгрөг	170,331,632.75	48,307,635.07
31211	Төрийн сангийн харилцах	170,331,632.75	48,307,635.07
35	БАРАА МАТЕРИАЛ	64,124,578.00	74,793,424.00
351	Түүхий эд материал	2,314,240.00	2,314,240.00
35110	Тусгай зориулалттай материал	2,314,240.00	2,314,240.00
354	Хангамжийн материал	61,810,338.00	72,479,184.00
35410	Бичиг хэргийн материал	2,422,900.00	2,422,900.00
35420	Аж ахуйн материал	46,716,748.00	53,852,938.00
35460	Хүнсний материал	6,694,540.00	11,514,196.00
35470	Бусад хангамжийн материал	4,689,150.00	4,689,150.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,405,944,050.22	2,401,836,164.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,405,944,050.22	2,401,836,164.70
392	Биет хөрөнгө	2,394,466,050.22	2,390,358,164.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,415,177,796.84	2,412,218,815.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(44,851,424.25)	(74,570,420.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,436,855.00	23,245,162.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,489,976.37)	(4,036,511.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,873,500.00	41,113,045.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,680,701.00)	(7,611,926.18)
393	Биет бус хөрөнгө	11,478,000.00	11,478,000.00
39301	Программ хангамж	900,000.00	900,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,578,000.00	10,578,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,640,400,260.97	2,524,937,223.77
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	53,143,905.00	83,097,015.77
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	53,143,905.00	83,097,015.77
413	Өглөг	53,143,905.00	83,097,015.77
4136	Бусад өглөг	53,143,905.00	83,097,015.77
41361	Байгууллагад төлөх өглөг	53,143,905.00	83,097,015.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,587,256,355.97	2,441,840,208.00
51	Засгийн газрын хувь оролцоо	2,587,256,355.97	2,441,840,208.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	314,706,769.00	314,706,769.00
51101	Өмч: - төрийн	314,706,769.00	314,706,769.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,249,852,274.87	2,104,436,126.90
51210	Өмнөх үеийн үр дүн	23,443,052.47	2,249,852,274.87
51220	Тайлант үеийн үр дүн	2,226,409,222.40	(145,416,147.97)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,697,312.10	22,697,312.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,640,400,260.97	2,524,937,223.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,927,831,600.00	795,836,316.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,222,065,000.00	49,697,216.53
120	Нийтлэг татварын бус орлого	2,222,065,000.00	49,697,216.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	35,000.00

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,220,960,000.00	45,802,866.53
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,000,000.00	3,859,350.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	705,766,600.00	746,139,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	647,441,800.00	590,941,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	647,441,800.00	590,941,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,324,800.00	155,197,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,324,800.00	155,197,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	701,422,377.60	941,252,464.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	701,422,377.60	941,252,464.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	700,252,513.22	936,193,288.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	440,858,448.45	568,212,707.86
210101	Үндсэн цалин	287,408,180.83	348,924,164.03
210102	Нэмэгдэл	137,475,802.62	182,947,078.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,895,000.00
210104	Урамшуулал	15,974,465.00	16,446,465.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,117,746.06	68,351,610.82
210201	Тэтгэврийн даатгал	36,112,546.06	46,109,310.82
210202	Тэтгэмжийн даатгал	5,001,200.00	5,562,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,500,700.00	2,781,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,500,700.00	2,781,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,002,600.00	11,116,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,498,840.62	181,378,534.52
210301	Гэрэл, цахилгаан	6,530,135.62	6,940,848.75
210302	Түлш, халаалт	100,468,705.00	171,437,710.77
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,999,975.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,788,207.00	5,101,160.00
210408	Бараа материал акталсны зардал	13,788,207.00	5,101,160.00
2105	Нормативт зардал	39,145,540.00	41,149,053.00
210502	Хоол, хүнс	39,145,540.00	41,149,053.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	225,000.00	3,174,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	225,000.00	3,174,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,870,731.09	68,826,222.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,802,350.00	15,888,970.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,927,100.00	3,026,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,141,281.09	49,910,752.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,169,864.38	5,059,176.25
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,169,864.38	5,059,176.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,169,864.38	5,059,176.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,226,409,222.40</u>	<u>(145,416,147.97)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>705,871,600.00</u>	<u>746,174,100.00</u>

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,000.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	105,000.00	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	705,766,600.00	746,139,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	647,441,800.00	590,941,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	647,441,800.00	590,941,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,324,800.00	155,197,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	58,324,800.00	155,197,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	616,174,394.51	868,198,097.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	616,174,394.51	868,198,097.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	615,004,530.13	863,138,921.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	440,858,448.45	568,212,707.86
210101	Үндсэн цалин	287,408,180.83	348,924,164.03
210102	Нэмэгдэл	137,475,802.62	182,947,078.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,895,000.00
210104	Урамшуулал	15,974,465.00	16,446,465.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,117,746.06	68,351,610.82
210201	Тэтгэврийн даатгал	36,112,546.06	46,109,310.82
210202	Тэтгэмжийн даатгал	5,001,200.00	5,562,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,500,700.00	2,781,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,500,700.00	2,781,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,002,600.00	11,116,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,354,935.62	150,138,423.75
210301	Гэрэл, цахилгаан	6,530,135.62	6,940,848.75
210302	Түлш, халаалт	47,324,800.00	140,197,600.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,999,975.00
2105	Нормативт зардал	36,501,350.00	45,968,709.00
210502	Хоол, хүнс	36,501,350.00	45,968,709.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	225,000.00	3,174,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	225,000.00	3,174,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,147,050.00	27,293,470.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,235,950.00	21,215,770.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,911,100.00	6,077,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,169,864.38	5,059,176.25
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,169,864.38	5,059,176.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,169,864.38	5,059,176.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	89,697,205.49	(122,023,997.68)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	88,441,205.49	(122,023,997.68)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	81,890,427.26	170,331,632.75
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	170,331,632.75	48,307,635.07

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	314,706,769.00	22,697,312.10	23,443,052.47	360,847,133.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	314,706,769.00	22,697,312.10	23,443,052.47	360,847,133.57
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	2,226,409,222.40	2,226,409,222.40
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	314,706,769.00	22,697,312.10	2,249,852,274.87	2,587,256,355.97
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	314,706,769.00	22,697,312.10	2,249,852,274.87	2,587,256,355.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	314,706,769.00	22,697,312.10	2,249,852,274.87	2,587,256,355.97
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(145,416,147.97)	(145,416,147.97)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	314,706,769.00	22,697,312.10	2,104,436,126.90	2,441,840,208.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

ЭЗА	ҮЗҮҮЛЭЛТ	БАТАЛСАН ТӨСӨВ	ГҮЙЦЭТГЭЛ	ХЭТРЭЛТ, ХЭМНЭЛТ	ХУВЬ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	900,451,700.00	863,138,921.43	37,312,778.57	95.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	900,451,700.00	863,138,921.43	37,312,778.57	95.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	900,451,700.00	863,138,921.43	37,312,778.57	95.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	589,301,900.00	568,212,707.86	21,089,192.14	96.4
210101	Үндсэн цалин	378,410,800.00	348,924,164.03	29,486,635.97	92.2
210102	Нэмэгдэл	199,751,500.00	182,947,078.21	16,804,421.79	91.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,895,000.00	(19,895,000.00)	-
210104	Урамшуулал	11,139,600.00	16,446,465.62	(5,306,865.62)	147.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,436,900.00	68,351,610.82	5,085,289.18	93.1
210201	Тэтгэврийн даатгал	49,839,200.00	46,109,310.82	3,729,889.18	92.5
210202	Тэтгэмжийн даатгал	5,899,400.00	5,562,000.00	337,400.00	94.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,949,700.00	2,781,900.00	167,800.00	94.3
210204	Ажилгүйдлийн даатгал	2,949,700.00	2,781,900.00	167,800.00	94.3
210205	Эрүүл мэндийн даатгал	11,798,900.00	11,116,500.00	682,400.00	94.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	155,197,600.00	150,138,423.75	5,059,176.25	96.7
210301	Гэрэл, цахилгаан	12,000,000.00	6,940,848.75	5,059,151.25	57.8
210302	Түлш, халаалт	140,197,600.00	140,197,600.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,999,975.00	25.00	100.0
2105	Нормативт зардал	51,989,800.00	45,968,709.00	6,021,091.00	88.4
210502	Хоол, хүнс	51,989,800.00	45,968,709.00	6,021,091.00	88.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,177,700.00	3,174,000.00	3,700.00	99.9

Говь-Алтай аймгийн Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,177,700.00	3,174,000.00	3,700.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,347,800.00	27,293,470.00	54,330.00	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,270,000.00	21,215,770.00	54,230.00	99.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,077,800.00	6,077,700.00	100.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	900,451,700.00	741,114,923.75	159,336,776.25	82.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	594,347,300.00	590,941,500.00	3,405,800.00	99.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	594,347,300.00	590,941,500.00	3,405,800.00	99.4
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	155,197,600.00	150,138,423.75	5,059,176.25	96.7
132001	Орон нутгийн төсвөөс	155,197,600.00	150,138,423.75	5,059,176.25	96.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	150,906,800.00	35,000.00	150,871,800.00	0.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		35,000.00	(35,000.00)	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	150,906,800.00		150,906,800.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		- 170,331,632.75	(170,331,632.75)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		- 48,307,635.07	(48,307,635.07)	-

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга гараагүй.

Залруулагдаагүй 1,029.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар төсвийн төлөвлөлт, бүртгэлтэй холбоотой 3 зөрчил илэрч, 817.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 212.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

Байгууллагын нягтлан бодогч Ч.Ундралчимэгт цалин, урамшуулал олгохдоо албан тушаалын үндсэн цалингаас тооцон 817.0 мянган төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн эрхлэгчийн 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/05 дугаар тушаал гаргаж, тушаалаар өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 15,895.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжийг хүрээнд албан хаагчдад олгох хоол, унааны хөнгөлөлтийг төсөвт тусгуулан, батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах.

Хоёр. Газрын төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага газрын төлбөрт 212.0 мянган төгрөгийг төлсөн нь Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Дараах төлбөр төлөгчийг дор дурдсан газрыг эзэмшиж, ашигласны төлбөрөөс чөлөөлнө", 8.1.5-т "төрийн болон орон нутгийн өмчийн асрамжийн болон бүх шатны боловсролын байгууллагыг улсын тусгай хамгаалалттай газраас бусад газар дахь эзэмшиж, ашиглаж буй газрынх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, газрын төлбөрийг төсвөөс төлөхгүй байх зөвлөмж хүргүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэг	Тус байгууллага газрын төлбөрт 212.0 мянган төгрөгийг төлсөн.	1	212.0	-	-	-	-	1	212.0	-	-
	Байгууллагын нягтлан бодогч Ч.Ундралчимэгт цалин, урамшуулал олгохдоо албан тушаалын үндсэн цалингаас тооцон 817.0 мянган төгрөгөөр илүү олгосон.	1	817.0	1	817.0	-	-	-	-	-	-
	Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн тушаалаар өдөрт 5,0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 19,055.0 мянган төгрөгийг олгосон.	1	-	-	-	-	-	-	-	-	-
								1			
	-Дүн	3	1,029.0	1	817.0	-	-	2	212.0	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			